

Архангай аймгийн музейн нээлттэй мэдээллийн нэгдсэн мэдээллийн
жилийн эцсийн тайлан

2024.12.04

Шийдвэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилт	Үнэлгээ /хүчингүй болсон хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
Монгол улсын хууль						
3	3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02	19.1.8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10- ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх;	Архангай аймгийн музей нь нийт 10 ажилтантай. Ажлын байран дахь жендэрийн харьцаа 5 эмэгтэй, 5 эрэгтэй байна. Ажил хөдөлмөр ба ар гэрийн амьдралын тэнцвэртэй байдлыг хадгалах, ажиллагсдын ажлын цагийн хуваарь, амрах хугацаа, гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэх, хүүхдээ асрах цалинтай чөлөө авахыг дэмжиж ажиллаж байна. Нийт албан хаагчдыг Эрүүл мэндийн эрт илрүүлээгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд 2024 оны 11-р сарын 15-ны өдөр хамруулсан.	100%	
5	16	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Байгууллагын хүний нөөцийн стратеги, нийт ажилчдын сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан батлан хэрэгжүүлэн ажиллаа. 2024 оны жилийн эцсийн байдлаар: Соёлын яам болон бусад төрийн байгууллагуудаас зохион байгуулсан нийт 26 удаагийн сургалтад байгууллагын 10 ажилтан хамрагдсан байна. Мөн аймгийн ЗДТГ-аас цаг үеийн болон, сар бүр зохион байгуулдаг аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд байгууллагын удирдлага тогтмол оролцож, өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг ханган ажилласан. Төрийн албаны зөвлөлөөс цахимаар явуулж буй сургалтад тогтмол хамрагдсан.	100%	

10	29	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Байгууллагын ил тод байдлын самбарт холбогдох мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт шинэчлэн, тогтмол байрлуулан ажиллаж байна. Мөн байгууллагаас зохион байгуулагдаж байгаа ажил үйлчилгээг байгууллагын цахим хуудсанд байрлуулан, орон нутгийн “АВ”, “Тамир” телевизтэй хамтран иргэд олон нийтэд тогтмол сурталчилан ажиллаж байна.	100%	
	30		8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Музей нь Эрдэнэбулган сум II баг, холбогдох албан тушаалтны 70332281, 99339269 утасны дугаар, ажиллах цагийн хуваарь болон бусад мэдээллийг Архангай Музей фэйсбүүк хуудас болон байгууллагын museum.ar.gov.mn сайтад тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна.	100%	
	31		8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	2023 оны жилийн эцсийн балансад Архангай аймаг дахь төрийн аудитын газар хяналт шалгалт хийж Дотоод хяналт шалгалт хийгээгүй, эхний хагас жилд үндсэн хөрөнгө тоолоогүйтэй холбоотой Албан шаардлага ирүүлсэн. Мөн албан хаагчдын эхний хагас жилийн үр дүнгийн цалинг зөрүүтэй бодсонтой холбоотой Акт ирүүлсэн. Акт, албан шаардлагад дурдсан ажлыг бүрэн хийж хариуг тухайн байгууллагад “Албан тоот”-оор хүргүүлж мөн “info shilen dans.gov.mn” хуудсанд байршуулсан	100%	
	32		8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Музейн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, бусад холбогдох хуульд нийцүүлэн жилийн эцсийн байдлаар /А, Б тушаал-17/ тушаал шийдвэрийг гаргаж холбогдох мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	100%	
	33		8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, байгууллагын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт болон бусад хөгжлийн баримт бичигтэй холбоотой 9 заалт, арга хэмжээ байдаг бөгөөд хэрэгжүүлсэн ажлын үр дүн, хамрагдалт зэргийг Архангай Музей фэйсбүүк хуудас болон орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан 93 удаа байршуулсан.	100%	

	34		8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Байгууллагын үйл ажиллагаандаа Соёлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Музейн тухай хууль гэх мэт хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж, Музейн тухай хуулийн 5.5-д заасны дагуу Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах бичиг баримтын бүрдэлийг ханган холбогдох газарт хүргүүлэн, ССАЖЗ-ын сайдын 2024 оны 08-р сарын 15-ны өдрийн А/12 тоот дугаар тушаалаар 8 жилийн хугацаатай тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гардан авч, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.	100%	
	35		8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Байгууллагын үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн ил тод байдлын самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан ажиллаж байна.	100%	
	36		8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Үйлчилгээний талаарх иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, гарсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажил хэрэг болгож ажиллах үүднээс нээлттэй утас болох 70332281 болон бусад төрлийн арга хэлбэрээр иргэдийн санал өргөдөл гомдлыг хүлээн авч шуурхай ажиллаа. Архангай аймгийн музейд иргэдээс Утсаар-5, Бичгээр-0, Цахим хэлбэрээр-10 гомдол, санал ирснийг холбогдох журамд заасан хугацаанд шийдвэрлэн ажиллаа.	100%	
	37		8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Соёлын салбарын статистик мэдээ, асуулга, судалгааг заасан хугацаанд тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Мөн cis.mn сайтад байгууллагын 2023, 2022, 2021 оны статистик мэдээг оруулж байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл дээр бүртгэлтэй 10 барилга, байгууламжийг бүртгэн орууллаа.	100%	
	38		8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	-	ҮБ	
	39		8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Музейн бүртгэл мэдээллийн санч Э.Баярмаа нь дикритний амралт авсан тул түр ажлын байрны сонгон шалгаруулах зарыг байгууллагын цахим	100%	

			хуудсанд байршуулан, сонгон галгаруулах ажлын зохион байгуулан Р. Нарантуяаг шалгаруулан музейн бүртгэл мэдээллийн санчийн түр орон тоонд томилон ажиллуулж байна.		
40		8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Музейн бүртгэл мэдээллийн санч Э.Баярмаа нь дикритний амралт авсан тул түр ажлын байрны сонгон шалгаруулах зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулан, сонгон галгаруулах ажлын зохион байгуулан Р. Нарантуяаг шалгаруулан музейн бүртгэл мэдээллийн санчийн түр орон тоонд томилон ажиллуулж байна.	100%	
41		8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Соёлын тухай хууль, Музейн тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолуудыг нийт ажилчдад танилцуулан, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Холбогдох хууль тогтоомжын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөг батлан жилийн эцсийн байдлаар: • Харилцах ур чадвар амжилтын үндэс. • Өөрийгөө өөрчилж, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх нь. • Ажилдаа хандах хандлага болон ажлын карьераа өсгөх нь. • Илтгэгчийн ур чадвар, түүнд суралцах нь. • Үр нөлөөтэй багийн ажиллагаа. • Гэр бүлийн сэтгэл зүйгээ эрүүл байлгах нь. • “Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм” • “Байгууллагын ажилтнуудын ёс зүй, үүрэг хариуцлага” танхимын сургалтуудыг НТБТ-тэй хамтран зохион байгуулж, байгууллагын нийт 10 ажилтан бүрэн хамрагдсан болно. • Аймгийн Прокурорын газрын Хяналтын прокурор Ж.Ундармаатай хамтран байгууллагын нийт албан хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулав.	100%	
42		8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Байгууллагын хүний нөөцийн стратеги, хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг нийт 10 албан хаагчдад танилцуулан, байгууллагын	100%	

				цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байрлуулан ажиллаа.		
43		8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;		Байгууллагын цахим хуудсанд болон www.museum.ar.gov.mn веб сайтад байгууллагын нийт ажилтны товч танилцуулгыг байршуулан, өөрчлөлт бүрд шинэчлэн, ил тод байдлыг ханган ажилласан байна.	100%	
44		8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.		Байгууллагын ажилчдын ажлыг, ажлын идэвхи санаачлага, хийж хэрэгжүүлж буй соёлын үйлчилгээ, үйл ажиллагааг дүгнэн үр дүнг үнэлэн, шагнаж урамшуулахдаа байгууллагын цахим хуудсандаа байршуулан цаг тухай бүр иргэдэд мэдээлэл хүргэж, сурталчилан ажиллаа. Мөн байгууллагын мэргэжилтнүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн тайланг Төрийн албаны зөвлөлийн 134-р тогтоолоор батлагдсан журмын дагуу дүгнэн ажиллаа. Үр дүнгийн урамшуулалд 6467300 / зургаан сая дөрвөн зуун жаран долоон мянга гурван зуун/ төгрөг олгосон байна.	100%	
45		8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;		2023 онд улсын төсвийн гүйцэтгэл 253514,6 мян.төг Орон нутгийн төсвөөс 25947,2 төг-өөр тус тус санхүүжиж, үндсэн үйл ажиллагааны орлогод 24985,8 төвлөрүүлэн ажилласан. 2024 онд Улсын төсвөөс 278350,7 мян.төгрөгийн Орон нутгийн төсвөөс 25947,2 мян.төгрөгөөр тус тус санхүүжин ажиллаж байна. 2025 оны төсвийн төслийг 364120,8 мянган төгрөгөөр боловсруулан хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн.	100%	
46		8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;		2024 онд 278350,7 мянган төгрөгийн батлагдсан төсөвтөө санхүүжиж хагас жилийн тайланг хуулийн хугацаанд гаргаж “Э тайлан” системд шивж байршуулсан.	100%	
47		8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;		2023 оны жилийн эцсийн тайланд Архангай аймаг дахь Төрийн Аудитын газрын хяналт шалгалтанд хамрагдаж зөрчилгүй дүгнэлт авсан.	100%	
48		8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;		2024 онд үндсэн үйл ажиллагааны орлогод 25194,4 мян.төг төвлөрүүлэн ажиллаж байна.	100%	

	49		8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Тухайн жилийн төсвийн зарцуулалтыг сар бүр тайлбарын хамт shilendans.gov.mn-д байршуулж ажилладаг.	100%	
	50		8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	2024 оны байдлаар 5,000.0 сая төгрөгөөс дээш үнэ бүхий худалдан авалт хийгээгүй.	100%	
	51		8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	2024 оны байдлаар 5,000.0 сая төгрөгөөс дээш үнэ бүхий зарлагын гүйлгээ хийгээгүй. Орлогын гүйлгээ 1-12 сарын сар бүрийн улсын төсвийн санхүүжилт орж байна.	100%	
	52		8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Манайд хамааралгүй заалт	ҮБ	
	53		8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	2024 онд 171-н мэдээллийг шилэн дансны shilendans.gov.mn сайтад үнэн зөв хугацаандаа бүрэн байршуулсан. 2023 оны жилийн эцсийн тайланд хийсэн Аудитын шалгалтаар Шилэн дансны хөтлөлттэй холбоотой зөрчил гараагүй.	100%	
	54		8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	Манайд хамааралгүй заалт	ҮБ	
	55		8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Худалдан авах ажиллагаа байхгүй.	ҮБ	

56		8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Худалдан авах ажиллагаа байхгүй.	ҮБ	
57		8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	2024 оны байдлаар ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.	ҮБ	
58		8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	2024 оны байдлаар байгууллагын захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил байхгүй.	ҮБ	
59		8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Байгууллагын төсөв санхүүг ил тод, нээлттэй байлгах үүднээс сар бүрийн мэдээг тухай бүр shilendans.gov.mn болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулдаг.	100%	
60		8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Манайд хамааралгүй заалт	ҮБ	
61		8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Байгууллагын үйл ажиллагаандаа Соёлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Музейн тухай хууль гэх мэт хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж, Музейн тухай хуулийн 5.5-д заасны дагуу Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах бичиг баримтын бүрдэлийг ханган холбогдох газарт хүргүүлэн, ССАЖЗ-ын сайдын 2024 оны 08-р сарын 15-ны өдрийн А/12 тоот дугаар тушаалаар 8 жилийн хугацаатай тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гардан авч, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.	100%	
62		8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга,	Соёлын салбарын хэмжээнд одоогоор байхгүй.	ҮБ	

			холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;			
	63		8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Архангай аймгийн музейд эзэмшдэг оюуны өмчийн эрх байхгүй болно.	ҮБ	
	64		8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Манайд хамааралгүй заалт	ҮБ	
	65		8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Тус байгууллага нь газар эзэмших №000001289 тоот гэрчилгээгээр 6513001214 нэгж талбарын дугаар бүхий 4367.0 м.кв газрыг тус тус эзэмшдэг болно.	100%	
	66		8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Манайд хамааралгүй заалт	ҮБ	
	67		8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	Ил тод байдлын хуулийн дагуу өөрийн байгууллагын пэйж хуудас, museum.ar.gov.mn сайтад болон байгууллагын ил тод байдлын самбарт удирдлага болон бусад албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж байна.	100%	
	68		8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас	Өмч эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, дүгнэн ажилласнаар албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан хэрэглэж буй техник, тоног төхөөрөмж, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сайжирч, улмаар	100%	

			гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.		
	69		8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Манайд хамааралгүй заалт		
	70		8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Манайд хамааралгүй заалт		
	71		8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Манайд хамааралгүй заалт		
	72		8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Манайд хамааралгүй заалт		
	73		8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Манайд хамааралгүй заалт		
	74		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.	Манайд хамааралгүй заалт		
Засгийн газрын тогтоол						
28	112	Монгол хэл бичгийн боловсролыг	4. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүх шатанд мөрдлөг	Аймгийн Засаг даргын 2022 оны №5 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах ажлын	100%	

		сайжруулах арга хэмжээний тухай 2013-02-02 Дугаар 05_2013_37	болгож төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	хүрээнд нийт ажилчдын монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулж, цаашид хүн тус бүрийн мэдлэгийн түвшинд тохирох сургалтыг Эрдэнэбулган сумын V сургуулийн “Монгол хэл бичгийн багш”, Монгол улсын зөвлөх багш Д.Дуламсүрэнтэй хамтран зохион байгуулан ажиллаа. Сургалтад байгууллагын нийт 10 ажилтан хамрагдсан болно.		
49	140	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	- Аймгийн Засаг даргын 2022 оны №5 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд нийт ажилчдын монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулж, цаашид хүн тус бүрийн мэдлэгийн түвшинд тохирох сургалтыг Эрдэнэбулган сумын V сургуулийн “Монгол хэл бичгийн багш”, Монгол улсын зөвлөх багш Д.Дуламсүрэнтэй хамтран зохион байгуулан ажиллаа. Сургалтад байгууллагын нийт 10 ажилтан хамрагдсан болно. - Бичиг хэргийн ажилтны компьютер дээр хэлний сонголтод монгол бичгийн форматыг суулгаж үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж байна. - Нийт ажилчид монгол бичгийн сургалтад хамрагдаж, монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалтад хамрагдан цаашид бие даан суралцаж уншиж, бичих мэдлэг чадвараа дээшлүүлж байна.	100%	
	156	2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 49	XIII.5.2. Төрийн болон орон нутгийн музейн харуул хамгаалалтын чиг	- Музейн захирлын 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/03 тоот тушаалаар музейн аюулгүй	100%	

63		дүгээр тэмдэглэл 2021-08-31 Дугаар 2021_49	үүргийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, зааварчилгааг хамтран баталж мөрдүүлэх, харуул хамгаалалтын ажилтны ур чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	байдлын үзлэг шалгалтын удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдөр камер болон дохиоллын системийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж ажиллахгүй болсон 1 камерыг сэлбэн засаж хэвийн үйл ажиллагаанд орууллаа. Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд музейн гадна талбай болон дотор талын явган хүний зам талбайд нарны зайн хураагуураар ажилладаг 65 ширхэг гэрлийг шинээр суурилуулан ашиглалтад орууллаа.		
	157		XIII.5.4. Харьяалах нутаг дэвсгэр дэх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	- Архангай аймгийн Музейд 1739 дэсийн 3947ш үзмэр хадгалагдаж байгаа бөгөөд түүний 30 гаруй хувь нь үзүүлэлт дэглэгдэж байна. - Улсын хамгаалалтад байх 22 дурсгал, аймгийн хамгаалалтад байх 35 үл хөдлөх дурсгалыг харьяалах Засаг дарга, иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан 100% хамгаалж байна. Сумын хамгаалалтад байх 266 дурсгалын 50 хувь нь иргэн болон хуулийн этгээдийн хамгаалалтад байна. - Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд хууль бус малтлага гараагүй.	100%	
69	165	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	Архангай аймгийн музей нь олон нийт боловсролын ажлын хөтөлбөрөөр бага насны хүүхдүүд, ЕБС-ийн сурагчид, их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн оюутан, насанд хүрэгчид, ахмад настнуудад зориулан музей болон музейгээс гадуурх орчинд танин мэдэхүйн сургалт үйл ажиллагааг тухай бүр зохион байгуулж Архангай музей цахим хуудсанд байршуулж, орон нутгийн “АВ”, “Тамир” телевизтэй хамтран иргэд олон нийтэд тухай бүр сурталчилан ажиллаж байна. Мөн museum.ar.gov.mn байгууллагын сайтыг шинээр хийлгэн байнгын ашиглалтад орууллаа.	100%	
75	176	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл	XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд	Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллага болон байгууллагын	100%	

		2022-05-11 Дугаар 2022_28	бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	нийт 10 албан хаагчид тоон гарын үсэгт бүрэн хамрагдлаа.		
--	--	--	---	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:
 САН ХӨМРӨГЧ
 ХЯНАСАН:
 ЗАХИРАЛ

Б. БААТАРХҮҮ
 Т. МӨНХБҮРЭН